

**Халдварт өвчин судлалын үндэсний төв байгуулагдсаны
20 жилийн ойд зориулав**

SARS- АЦХаХ АМЬСГАЛЫН ЦОЧМОГ ХАЛТАЙ ХАМШИНЖ



2003 оны эхээр БНХАУ болон Зүүн Азийн зарим оронд олон хүнийг хамран өвчлүүлсэн амьсгалын цочмог дутлаар илрэх халдварт өвчин гарсан нь коронавирусууд сэдээгддэг шинэ халдварт өвчин болох нь тогтоогдож SARS (Severe acute respiratory syndrome) буюу АЦХаХ (амьсгалын цочмог халтай хамшинж) нэр авсан билээ [1].

АЦХаХ өвчин импортлогдсонтой холбоотойгоор БНХАУ-аас Монгол улсад хил гаалиар нэвтрэн



1. А - гэр бүл, 5 ам бүлтэй. А - гэр бүлийн өвчтөн №1 Н.С 60 настай эмэгтэй, энэ өвчтөн Хараа-1 эмнэлэгт 2003 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс 16 хоног эмчлүүлэхдээ 2003 оны 3 дугаар сарын 29-ы өдөр халуурч, ганц нэг ханиалгаж эхэлсэн бөгөөд 2003 оны 4 дүгээр сарын 1-нд эмнэлгээс гарч галт тэргэнд нөхөр, охин, зээ дөрвүүл нэг тасалгаанд сууж, 2003 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр Улаанбаатар хотод иржээ. Хөх хот дахь Монгол улсын Ерөнхий консулын газраас манай улсын Гадаад харилцааны яаманд ирүүлсэн SARS -ийн тухай мэдээлэлд “Өвөр монголын

орох хөдөлгөөнд онцгой журам тогтоож, энэ өвчний дэгдэлтийг богино хугацаанд хязгаарлан барьж чадав. Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын хүн амын дунд 2003 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс 5 дугаар сарын 15-ны өдөр нийт 34 хоногийн хугацаанд SARS бүхий 9 тохиолдол илэрч оношлогдон, эмчлэгдэн эдгэрч, эмнэлгээс гарчээ. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Хараа-1 эмнэлэгт 2003 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс 4 дүгээр сарын 2-ны өдөр хүртэл 16 хоног манай улсын 6 иргэн нэг өрөөнд байрлаж байжээ. Тэдгээрээс 4 хүн нь SARS -аар өвчилсөн ба А, В, С гэсэн 3 гэр бүлийн хүмүүс байжээ [2]. АЦХаХ-ын коронавирусийн РНХ-г илрүүлэх болон эсрэгбие илрүүлэх шинжилгээгээр бүрэн батлагджээ. 1 нь эзгийгээ асарч байх явцдаа халдвар авч өвчилсөн орон нутгийн дотоодын халдвар юм. Удаах 3 тохиолдол нь Бээжин хотод сурч байсан оюутнууд бөгөөд оношийг эмнэлзүйн жишгээр тогтоосон болно [1]


Хятад-Монгол эмнэлэг”-ийн-хороонд хэвтэн эмчлүүлэгчдийн дундаас SARS -аар өвчилсөн зарим хүн илэрсэн тухай гадуур яригдаж байгаа мэдээллийг Эрүүл мэндийн танхимын даргаас асуухад үгүйсгээгүй ч нотлоогүй байна. Энэ эмнэлэгт байсан SARS-ийн сэжигтэй өвчтөнг цээжний хөндийн эмнэлэгт шилжүүлсэн гэсэн мэдээлэл байлаа гэжээ. А-гэр бүлийн Н.С нь Хөх хотын Хараа-1 эмнэлэгт байхдаа 2003 оны 3 дугаар сарын 20-ны орчим SARS-ийн халдварыг авсан гэж үзвэл нууц үеийн хугацаа 10 хоног байжээ. Амьсгалын замын эрхтэний үрэвслийн эмнэлзүйн хамшинж эхэлж илэрснийг үндэслэн өвчтөн Н.С нь уг халдварыг эмнэлгийн нөхцөлд агаар дуслын замаар авсан гэж үзжээ.

2. А- гэр бүлийн өвчтөн №2 Д.Ю- 63 настай эрэгтэй, №1 Н.С-ийн нөхөр, Хөх хотын Хараа-1 эмнэлэгт эхнэрээ эмчлүүлэхэд асарч сувилалцаж, гадуур байсан. Өвчтөн Д.Ю нь 2003 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс халуурч, 2003 оны 4 дүгээр сарын 9-нд ханиалгаж эхэлсэн ба хөөмийн салст 2003 оны 4 дүгээр сарын 12-нд улайсан байжээ. Эхнэрээсээ халдвар авсан гэвэл нууц үеийн хугацаа нь 8 хоног байна. Энэ

өвчтөнд илэрсэн амьсгалын эрхтэний үрэвслийн хамшинж, хөөмийн улайлтыг үндэслэн халдварыг эхнэр Н.С-ээс агаар дуслын замаар авчээ гэж үзжээ.

3. А - гэр бүлийн өвчтөн №3 Ю.Б - 32 настай, эмэгтэй, Хөх хотын Хараа-1 эмнэлэгт ээж Н.С-ыг асарч, нэг өрөөнд байсан. Өвчтөн Ю.Б нь 2003 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөс 38 хэм хүртэл халуурч, 2003 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр ханиалгаж, хөөмийн салстын улайлт 2003 оны 4 дүгээр сарын 12-оос эхэлсэн. Эхээсээ уг халдварыг агаар дуслын замаар авчээ. Энэ тохиолдолд уг өвчтөний өвчний нууц үеийн хугацааг 10 хоног гэж үзлээ. А- гэр бүлийн 5 ам бүлийн 3 нь SARS-ээр өвчилсөн байна.

4. В-гэр бүл 13 ам бүлтэй. Үүнээс 2 нь SARS -ээр өвчилжээ. В гэр бүлийн өвчтөн №4 Д.Ц - 57 настай эмэгтэй, Хөх хотын нэгдсэн эмнэлгийн буудалд 2003 оны 3 дугаар сарын 17-ноос 3 хоног байгаад, Хараа-1 эмнэлэгт 2003 оны 3 дугаар сарын 20-ноос 4 дүгээр сарын 2-ныг хүртэл 14 хоног эмчилгээ хийлгээд, 2003 оны 4 дүгээр сарын 4 өдөр Бээжин- Хөх хот-Улаанбаатарын онгоцоор Улаанбаатар хотод гэртээ иржээ. Хөх хотын Хараа-1 эмнэлэгт нэг өрөөнд дээр дурьдсан өвчтөнүүд (№1, 2, 3)-тэй хамт байжээ. Өвчтөн Д.Ц нь 4 дүгээр сарын 5-наас халуурч, хоолой өвдөж, 4 дүгээр сарын 11-нд ханиалгасан ба 12-нд хөөмийн улайлттай байсан байна. Энэ өвчтөн эмнэлгийн нөхцөлд 2003 оны 3 дүгээр сарын 29-ний орчимд уг халдварыг агаар дуслын замаар авчээ гэж үзвэл нууц үеийн хугацаа 8 хоног байна.



5. В-гэр бүлийн өвчтөн №6, 3, 28 настай, эмэгтэй, ам бүл 2, нөхрийн хамт амьдардаг. Хөх хотоос 2003 оны 4 дүгээр сарын 4-нд эх Д.Ц-г ирэх үеэс гэрт нь асарч сувилж, үйлчилсэн байна. Өвчтөн 3 нь 2003 оны 4 дүгээр сарын 15-наас халуурч, суулгаж, ханиалгасан байна. Энэ өвчтөн SARS

-ийн халдварыг эхээсээ хавьтал - ахуйн замаар авсан ба нууц үеийн хугацаа нь 11 хоног байна. 6. С-гэр бүлийн ам бүл 7, өвчтөн №5 Ц.Д 59 настай эмэгтэй, Хөх хотын Хараа-1 эмнэлэгт 2003 оны 3 дугаар сарын 18-нд хэвтэж, өвчтөн №1, 2, 3, 4-тэй хамт байж, 2003 оны 3 дугаар сарын 24-ний өглөө 8 цаг хүртэл 7 хоног байгаад, Бээжин-Хөх хот-Улаанбаатарын онгоцоор 2003 оны 4 дүгээр сарын 4-нд өвчтөн Д.Ц-гийн хамт Улаанбаатарт иржээ. Өвчтөн Ц.Д нь 2003 оны 4 дүгээр сарын 7-ноос халуурч, ханиалгаж байсан ба 12-нд хөөмийн салст улайсан байжээ. Энэ өвчтөн нь эмнэлгийн нөхцөлд 2003 оны 3 дугаар сарын 24-ний орчим уг халдварыг агаар дуслын замаар авсан гэвэл нууц үеийн хугацаа нь 14 хоног байна.



7. Ө-гэр бүлийн ам бүл 4, өвчтөн №7 Ч.Н- 28 настай эмэгтэй, БНХАУ-ын Бээжин хотод аялал жуулчлалын дээд сургуулийн оюутан, сургуулиас нь SARS -ээр 3 хүн өвчилсөн мэдээ байсан гэж өвчтөн өөрөө мэдээлсэн байна. Өвчтөн Ч.Н нь 2003 оны 4 дүгээр сарын 23-наас халуурч, хоолой өвдөж эхэлсэн ба 26-нд ханиалгаж, хөөмийн салст улайсан байжээ. Энэ байдлыг үндэслэн уг халдварыг 2003 оны 4 дүгээр сарын 14-ний орчим агаар дуслын замаар авсан гэж үзвэл нууц үеийн хугацаа 14 хоног байна.

8. Е-гэр бүлийн ам бүл 4, өвчтөн №8 Ч.Б- 20 настай, эмэгтэй. БНХАУ-ын Бээжин хотод Бизнес эдийн засгийн сургуульд 2-р дамжааны оюутан. Сургуульд нь SARS гарсныг мэдээгүй. Гэвч сургуульд нь өвчин гарсан, хөл хорио тогтоосон мэдээг тэр сургуульд суралцдаг өөр оюутан мэдэж байсан. Ч.Б нь 2003 оны 4 дүгээр сарын 28-наас халуурч, 30-нд хоолой хөндүүрлэн өвдөж, 2003 оны 5 дугаар сарын 2-нд хөөмийн салст улайсан байжээ. Энэ байдлыг үндэслэн уг халдварыг 2003 оны 4 дүгээр сарын 18-ны орчим агаар дуслын замаар авсан гэж үзвэл нууц үеийн хугацаа 10 хоног байна.



9. Р -гэр бүл, ам бүл 6. Өвчтөн №9 Д.Б- 17 настай эмэгтэй, БНХАУ-ын Бээжин хотод Холбооны их сургуулийн бэлтгэл ангид суралцдаг оюутан. 2003 оны 4 дүгээр сарын 21-нд оюутны байранд нь Филиппин улсын оюутан SARS -ээр өвчилсөн. Мөн өөр 2 оюутан энэ өвчнөөр өвчилжээ. Өвчтөн Д.Б нь 2003 оны 4 дүгээр сарын 8-ны үеэс халуурсан, хоолой өвдсөн, хааяа ханиалгасан байна. 2003 оны 4 дүгээр сарын 18-аас цэр гарсан. Ханиадны хятад эм ууж байжээ. Өвчтөн Д.Б-д илэрсэн хамшинжээс үзэхэд уг халдварыг агаар дуслын замаар авсан ба нууц үеийн хугацаа 10 хоног байна.

Дүгнэлт:

1. БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны Хөх хотын Хараа-1 эмнэлэгт эмчлүүлсэн манай улсын иргэдээр эмнэлгээс шалтгаалах халдвар хэлбэрээр SARS -ийн халдвар 2003 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотод зөөвөрлөгдөн иржээ.
 2. БНХАУ-ын Бээжин хотод байдаг их, дээд сургуулиудад суралцдаг манай оюутнуудаар SARS -ийн халдвар дамжин 2003 оны 4, 5 дугаар саруудад Улаанбаатар хотод 2 дахь удаагаа зөөвөрлөгдөн ирэв.
 3. Манай улсад 2003 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс 5 дугаар сарын 15 нийт 34 хоногийн хугацаанд SARS -ийн 9 тохиолдлыг илрүүлж, эмнэлзүй, тархвар судлалын үзүүлэлтүүдийг үндэслэж оношлон, лабораториор баталгаажуулжээ.
- А. Өвчтөнүүдэд зонхилон-халуурах-ханиалгах-хоолой-өвдөх-амьсгал давчдах, толгой өвдөх, ядрах хамшинжүүд тохиолдсон байна.
5. Нэг голомтноос дунджаар 2 хүн өвчилсөн ба гэр бүлийн шинжтэй голомтлог байдал ажиглагдав.

6. Өвчтөнөөс SARS-ийн халдвар ихэвчлэн агаар дуслын замаар дамжин халдварласан.
7. Манай улсын хүн амын дунд гарсан SARS-ийн халдварын нууц үеийн хугацаа дунджаар 10 хоног байв.
8. Хүнамдхалдварлахболомж(контагиозность) -ийн хувьд 1000 хүн тутмаас 6 хүн, 10000 хүн тутмаас 68 хүн өвчлүүлэх боломжтой байна гэж үзэв [2].

Ийнхүү 2003-2020 он буюу 17 жилийн дараа короновирусээр үүсгэгддэг амьсгалын замын халдварт өвчин тив дэлхийг хамарч (пандеми) дахин тархлаа. Цар тахлыг тодорхойлдог 3 шинж байдаг бөгөөд Үүнд:

1. Олон орныг хамарсан байх (тив дэлхийг)
 2. Үхэл өндөртэй байх
 3. Шинэ төрлийн вирус үүссэн байдаг байна
- COVID-19 цар тахал нь дээр 3 тодорхойлолтыг бүрэн агуулжээ.

Ашигласан материал

1. П.Нямдаваа, Н.Цэнд, Н.Дондог, Р.Туул, А.Наранзул, Г.Зулхүү, Т.Одагариг, О.Аллар, Н.Жаргалсайхан, А.Бат-Очир, А.Гончигсүрэн, Б.Энхтуяа, С.Цогтсайхан, А.Эрдэнэчиллэг Монгол улсад импортлогдсон АЦХАХ-ын тохиолдлыг оношлож, тархалтыг таслан зогсоосон нь. Халдварт өвчин судлалын сэтгүүл 2004 он №3.
2. Үндэсний төв архив ХӨСҮТ. Фонд 426, Данс 2, ХН-142

*Анагаах ухааны доктор Л.Энхбаатар
2021 оны 1 дүгээр сарын 10*